**БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"**

(Эдийн засаг, хөгжлийн яам болон Засгийн газрын агентлагаас бусад харьяа байгууллагуудын хүрээнд)

| НЭГ.Товч танилцуулга |
|---|
| Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагуудын ёс зүйн дэд хороодын тайлан, мэдээллийг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасан хуваарь, бүтэц, шалгуурын дагуу дараах байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулла. Үүнд:<br><br>11. Эдийн засаг, хөгжлийн яам;<br>12. Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар болон түүний харьяа 16 хүрээлэн;<br>13. Шинжлэх ухаан, технологийн сан;<br>14. Шинжлэх ухааны паркийн захиргаа;<br>15. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн;<br>16. Анагаах ухааны хүрээлэн;<br>17. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн;<br>18. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн;<br>19. Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн;<br>20. Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн.<br><br>Дээрх байгууллагуудын хэмжээнд нийт 123 албан хаагч ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгогдон, өөрсдийн харьяа байгууллагын түвшинд төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Тодруулбал, ёс зүйн дэд хороод нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024–2030)"-ийн зорилго, зорилтуудтай уялдуулан байгууллагын дотоод зохион байгуулалт, ёс зүйн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, албан хаагчдыг ёс зүйтэй ажиллахад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах, ёс зүйн гомдол, мэдээллийг хууль, журмын дагуу хүлээн авч, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэвийн хэрэгжүүлж байна. |
| ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар |
| 2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт |
| Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024–2030)"-ийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам болон харьяа байгууллагууд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан |

сэргийлэх, ёс зүйтэй ажиллах соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллалаа.

1. Ёс зүйн дэд хороодын удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр

Тайлант хугацаанд холбогдох байгууллагуудын хэмжээнд Ёс зүйн дэд хороодыг байгуулж, холбогдох тушаал, шийдвэрийг батлан мөрдүүлж, дэд хороодын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн. Ёс зүйн дэд хороод нь төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг байгууллагын түвшинд хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэн ажилласан болно.

2. Соён гэгээрүүлэх, сургалт, нөлөөллийн ажлын хүрээнд

Төрийн албан хаагчдыг ёс зүйн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор давхардсан тоогоор нийт 32 арга хэмжээг зохион байгуулсан.Үүнд:

- төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн сургалт;
- цахим болон танхимын вебинар;
- чиглүүлэх сургалт;
- байгууллагын соёл, харилцаа, хандлагыг сайжруулах сэдэвт сургалт;
- Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах сургалт;
- удирдах болон томилох эрх бүхий албан тушаалтанд чиглэсэн ёс зүйн манлайллын сургалтуудыг зохион байгуулсан.

Дээрх сургалт, нөлөөллийн арга хэмжээг байгууллага тус бүрийн тухайд авч үзвэл:

1. Эдийн засаг, хөгжлийн яам – 4
2. Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар болон харьяа хүрээлэнгүүдийн хэмжээнд– 12
3. Шинжлэх ухаан, технологийн сан – 1
4. Шинжлэх ухааны паркийн захиргаа – 3
5. Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн – 1
6. Анагаах ухааны хүрээлэн – 1
7. Ургамал хамгаллын эрдэм шинжилгээний хүрээлэн – 2
8. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн – 5
9. Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн – 1
10. Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн – 2

Мөн шинээр томилогдсон албан хаагчдыг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулж, ёс зүйн дүрэм, журам, үндэсний хөтөлбөрийн агуулгыг танилцуулан соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлсэн.

3. Урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын чиглэлээр

Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагууд дараах арга хэмжээг нийтлэг байдлаар авч хэрэгжүүлсэн байна:

- дотоод цахим сувгаар ёс зүйн талаарх мэдээлэл, зөвлөмж түгээх;

- албан хаагчдын харилцаа, хандлагын талаарх судалгаа авч, гүйцэтгэлийн үнэлгээнд харгалзан үзэх;
- гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх дотоод тогтолцоог хэвшүүлэх.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагуудын томилох эрх бүхий албан тушаалтнууд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж байна. Түүнчлэн томилох эрх бүхий албан тушаалтнууд нь албан үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, иргэн, байгууллага, хамт олонтой харилцах бүхий л үйл ажиллагаандаа ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг чанд сахин мөрдөж, үлгэр жишээ манлайлал үзүүлэн ажилласан болно. Үүний үр дүнд тайлант хугацаанд Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагын нэг ч томилох эрх бүхий албан тушаалтантай холбогдуулан ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл ирээгүй байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагуудын ёс зүйн дэд хороод нь энэхүү тайлангийн 2.1 дэх хэсэгт тайлагнасан соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс гадна төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх, дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчлийн бүртгэл хөтлөх чиг үүргийг хууль, журмын дагуу хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд Эдийн засаг, хөгжлийн яаманд ёс зүйн зөрчилтэй холбоотой 1 гомдол, мэдээлэл ирсэн бөгөөд яамнаас бусад харьяа байгууллагад ёс зүйн гомдол, мэдээлэл ирээгүй байна.

Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн уг гомдол, мэдээллийг холбогдох журмын дагуу хүлээн авч, анхан шатны бүртгэлд бүртгэн, агуулга, харьяаллыг урьдчилан нягталж Ёс зүйн дэд хорооны бүрэн эрхэд хамаарах эсэхийг шалган үзсэн болно. Хянан үзэх явцад уг гомдол нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан Ёс зүйн дэд хорооны чиг үүрэгт хамаарахгүй болох нь тогтоогдсон.

Иймд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу уг гомдол, мэдээллийг шийдвэрлэх эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж, гомдол гаргагчид мэдэгдэн шийдвэрлэсэн байна. Бусад харьяа байгууллагуудын тухайд ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй. Гэсэн хэдий ч ёс зүйн дэд хороод нь гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд хууль, журмын дагуу шуурхай, нэгдсэн байдлаар ажиллах бэлэн байдлыг тогтмол хангаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно.

Тухайлбал, ёс зүйн дэд хороод нь гомдол, мэдээлэл хүлээн авах сувгуудыг тодорхой болгож, ирсэн гомдол, мэдээллийг бүртгэх, агуулга, харьяаллыг нягтлах, ёс зүйн дэд

хорооны бүрэн эрхэд хамаарах эсэхийг урьдчилан тодорхойлох дотоод ажиллагааны дарааллыг хэвшүүлсэн. Мөн ёс зүйн гомдол, мэдээлэлтэй ажиллахдаа нууцлалыг хангах, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, хараат бус байдлыг баримтлах зарчмыг мөрдөн ажиллах талаар дэд хорооны гишүүдэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Мөн тайлант хугацаанд ёс зүйн дэд хороод нь ёс зүйн зөрчлийн бүртгэлийг тогтмол хөтлөх, гомдол, мэдээлэл ирээгүй тохиолдолд ч бүртгэл, маягт, шийдвэрлэлтийн загварыг бэлэн байлгах, дэд хорооны хуралдаан зохион байгуулах боломж, гишүүдийн оролцоог хангах чиглэлээр дотоод зохион байгуулалтын бэлэн байдлыг хангасан болно.

| Гарсан үр дүн, ололт амжилт | Бэрхшээл |
|---|---|
| Тайлант хугацаанд Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагууд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу ёс зүйн дэд хороог байгуулж, тэдгээрийн үйл ажиллагааг зохион байгуулан тогтмол явуулж эхэлсэн.<br><br>Ёс зүйн дэд хороодоос нийт албан хаагчдыг хамруулсан сургалт, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулснаар албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх ойлголт, мэдлэгээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замын талаар практик мэдлэг, чадварыг эзэмшсэн. Үүний үр дүнд албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшин эерэг үнэлгээтэй байна. | Ёс зүйн гомдол, мэдээлэл ирэх тохиолдол харьцангуй ховор байгаа нь ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны практик туршлага хуримтлуулах боломжийг тодорхой хэмжээнд хязгаарлаж байна. Түүнчлэн ёс зүйн зөрчил хянан шалгах процесс ерөнхий байдлаар журамлагдсан, хянан шалгах ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон зохицуулалт хангалтгүй байгаа нь зарим тохиолдолд хянан шалгах ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах эрсдэлтэй байна.<br>Мөн Монгол Улсын Ёс зүйн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар зэрэг байгууллагуудаас ёс зүйн дэд хороодод хандан өөр өөр агуулга, форматтайгаар тайланг давтамжтайгаар гаргуулах нь ёс зүйн дэд хороодын гишүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах нөхцөл байдал үүсгэж байгааг харьяа байгууллагын ёс зүйн дэд хороодоос удаа дараа илэрхийлж байна. |

Санал:

1. Ёс зүйн гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, хянан шалгах ажиллагааны дотоод зохион байгуулалт, аргачлалыг нарийвчлан тодорхойлсон заавар, зөвлөмжийг боловсруулах, хянан шалгах ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгож, практикт хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх;

2. Ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны жишиг кейс, туршлагад суурилсан сургалт, дадлагажуулах арга хэмжээг ёс зүйн дэд хорооны гишүүдэд чиглүүлэн зохион байгуулж, практик ур чадварыг бэхжүүлэх;
3. Албан хаагчдад ёс зүйн гомдол, мэдээлэл гаргах эрх, журам, нууцлал, хамгаалалтын талаар чиглэсэн мэдээлэл, тайлбарыг тогтмол хүргэх, гомдол, мэдээлэл гаргах итгэлцлийг нэмэгдүүлэх;
4. Ёс зүйн дэд хороодын тайлагналтай холбоотой зохиомол ачааллыг бууруулах, тайлагналын чанар, нэгдмэл байдлыг хангах зорилгоор ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг нэгдсэн нэг шугамаар, төлөвлөгөөт байдлаар хүлээн авах асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хяналт хэрэгжүүлэх газартай хамтран зохион байгуулах. Энэ хүрээнд олон байгууллагаас өөр өөр агуулга, форматтайгаар давтамжтай тайлан гаргуулж байгаа нөхцөл байдлыг оновчтой болгох, тайлангийн бүтэц, шалгуур, хугацааг уялдуулах замаар ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаанд үүсэж буй зохиомол ачааллыг бууруулах.

Шалгах хэсэг:

- ☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

**Томилох эрх бүхий албан тушаалтан**

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга И.БАТХҮҮ

**Ёс зүйн дэд хорооны дарга**

Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.ЭНХ-АМГАЛАН

**Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга**

Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.ТҮВШИН

**БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"**

(Эдийн засаг, хөгжлийн яам болон Засгийн газрын агентлагаас бусад харьяа байгууллагуудын хүрээнд)

| № | Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | | Авбал зохих оноо | Оноо [1] | Хувийн жин [2] |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 |
| 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ) | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх | | 1 | 1 | 10 |
| 2 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх | | 1 | 0 | 0 |
| 3 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх | 0.5 | 0.5 | 5 |
| | | | Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал | 0.5 | 0.5 | 5 |
| | | | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал | 0.5 | 5 | 5 |
| | | | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал | 0.5 | 0.5 | 5 |
| **Хэсгийн оноо** | | | | **4** | **2.5** | **25** |
| 4 | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ) | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх[10] | | 1 | 1 | 10 |
| 5 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал [11] | | 1 | 1 | 10 |
| 6 | | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12] | | 1 | 1 | 10 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | **3** | **30** |
| 7 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ) | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13] | | 1 | 1 | 10 |
| 8 | | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал[14] (Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно) | | 1 | 1 | 10 |
| 9. | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал[15] | | 1 | 1 | 10 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | **3** | **30** |
| **Үнэлгээний нийт оноо, хувь** | | | | **10** | **9** | **90%** |

---oOo---

БАТЛАВ:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАН

2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

# ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

| Д/Д | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах нэгж, албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөрийн хүрээнд** | | | | | | | |
| 1.1 | Албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас хөтлөх | Улсын төсөв | Бүртгэл хөтөлсөн тоо | 0 | Тухай бүр | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн |
| 1.2 | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим зөвлөмж, уриалга, богино бичлэг бэлтгэн түгээх | Улсын төсөв | Нийтэлсэн мэдээллийн тоо | 0 | 1 | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн |
| 1.3 | Ёс зүйн зөрчлөөс үрьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Сургалт зохион байгуулсан тоо | 1 | 2-оос доошгүй | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн |
| **Хоёр. Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах, тайлагнах зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 2.1 | Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгаж, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах | Улсын төсөв | Тэмдэглэл, дүгнэлт, тайлан | 0 | Тухай бүр | Жилдээ | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга |
| **Гурав. Дэд хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг тогтворжуулах зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 3.1 | Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө | Улсын төсөв | Хүргүүлсэн тайлангийн тоо | 0 | 1 | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлах, үйл ажиллагааны тайланг удирдлага болон холбогдох байгууллагад хүргүүлэх | | | | | | |
| 3.2 | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг чадавхжуулах, сургалтад хамрагдах | Улсын төсөв | Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо | 0 | 1-ээс доошгүй удаа | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн |
| 3.3 | Ёс зүйн хорооноос хорооноос зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох | Улсын төсөв | Хамрагдсан арга хэмжээний тоо | 0 | Тухай бүр | I-IV улирал | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн |
| 3.4 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлан, мэдээллийг нийтэл ил тод байршуулах | Улсын төсөв | Байршуулсан мэдээллийн тоо | 0 | Тухай бүр | I улирал | Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга |
| 3.5 | Ёс зүйн дэд хорооны бланкны загварыг гаргаж, хэвлүүлэх | Улсын төсөв | Хэвлүүлсэн бланкны тоо хэмжээ | 0 | 500 ширхэг | II улирал | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн |

Төлөвлөгөө боловсруулсан:

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга П.Түвшин